

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЗОРИЛГО

Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн, дэлхийн жишигт дүйцэхүйц эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрдэм шинжилгээний салбар анх 1961 онд Шинжлэх Ухааны Академийн харъяа Анагаах ухааны хүрээлэнгийн “Хүүхэд, Эх барих Эмэгтэйчүүдийн сектор” нэртэйгээр байгуулагдаж, 1976 онд “Эх нялхсыг хамгаалах Эрдэм шинжилгээний хүрээлэн” нэртэй болж өргөжсөн юм. БНМАУ-ын Сайдын нарын Зөвлөлийн 1987 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 43 дугаар тогтоолоор “Улсын эх нялхсын нэгдсэн төв”-ийг “Эх нялхсыг хамгаалах Эрдэм шинжилгээний хүрээлэн”-тэй нэгтгэж “Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах Эрдэм шинжилгээний улсын нэгдсэн төв” (ЭХЭМХЭШУНТ) болгон зохион байгуулсан бөгөөд 2011 оноос ЭХЭМҮТ-ийн “Эрдэм шинжилгээний салбар” болж үйл ажиллагаагаа явуулж байна.

2025 оны байдлаар Эрдэм шинжилгээний салбар нь 5 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байна.

2025 онд төсөл хөтөлбөр 10, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл 10, олон улсын сэтгүүлд 7 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн.

№	Овог, нэр	Албан тушаал	Мэйл хаяг
1	Д.Энхмаа	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	enkhmaa.d@ncmch.gov.mn
2	Т.Эрхэмбаатар	Зөвлөх	dr.erhembraatar@gmail.com
3	О.Амаржаргал	Эрдэм шинжилгээний дэд ажилтан	amarjargal.ol@ncmch.gov.mn
4	Э.Насантогтох	Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан	nasantogtokh.e@ncmch.gov.mn
5	Ц.Ариунзаяа	Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан	ariunzaya.ts@ncmch.gov.mn



Үйл ажиллагаа

Эрдэм шинжилгээний салбар нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- ЭМЯ-нд Анагаах ухааны тэргүүлэх чиглэлээр төслийн санал хүргүүлэх
- ШУТС-ийн санхүүжилттэй ШУТ-ийн захиалгат, суурь, цөм, инновацийн төслүүдэд ажиллах
- Гадаадтай хамтарсан төслүүдэд ажиллах
- Төвийн эмч, мэргэжилтнүүдийн доктор, магистрын судалгааны ажилд арга, зүйн зөвлөгөө өгөх
- Резидент эмч нарын хичээлийн хөтөлбөрт судалгааны арга зүй, статистик боловсруулалтын талаар тусгай хичээлийн сэдвүүдийг оруулах, судалгаа хийх сэдвүүдийг батлах, арга зүйн зөвлөгөө өгөх
- Эх баригч, сувилагч нарт тодорхой төлөвлөгөөний дагуу судалгааны ажлын арга, зүйн талаар үе шаттай сургалт тогтмол зохион байгуулах, судалгаа хийх сэдвүүдийг батлах, судалгааны ажилд арга зүйн зөвлөгөө өгөх
- Нийт эмч нарт захиалгат төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл, зэхэц ажлын мэдээлэлийг өгөх
- “Эх барих,эмэгтэйчүүд,хүүхэд судлал” сэтгүүлийг хариуцан гаргаж, цахим хэлбэрт оруулж төвийн сайтад байршуулах
- Төсөлт ажлуудын үр дүнгийн даалгаварыг хүлээлгэн өгөх
- Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах



“Эх барих,эмэгтэйчүүд,хүүхэд судлал” сэтгүүлд

Эрдэм шинжилгээний бүтээлийн хураангуй хүлээн авах журам

Зорилго: Эрдэм шинжилгээний хурлаар эрдэмтэн, эмч, эх баригч, судлаачдын эх ургийн анагаах ухаан, эх барихуйн судлал, эмэгтэйчүүд судлал, эрчимт эмчилгээ, нярай, хүүхэд судлал, хүүхдийн мэс засал судлал, чиглэлээр туурвисан судалгаа шинжилгээний ажлын үр дүн, бүтээлийг мэргэжил нэгт судлаач нартай хуваалцан, цаашдын эрдэм судлалын хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл хийж, санал солилцох.

Бүтээлд тавигдах ерөнхий шаардлага

- Нэг судлаач 2 хүртэлх тооны бүтээл ирүүлж болно.
- Монгол хэл дээр үндсэн илтгэлийг 2-3 хуудсанд багтаан Arial фондоор, үсгийн өндөр 12-оор бичигдсэн байх шаардлагатай.
- Нэг илтгэлд 2-оос илүүгүй график, 1-ээс илүүгүй хүснэгтэн мэдээллийг зөвшөөрнө.
- Илтгэгчийн нэрийн (1 илтгэгч байна) доогуур зурж тодруулсан байх.
- Судалгааны ажил нь бүтээлийн нэртэй дүйцэж байх.

Бүтээлийн бүтэц:

- Илтгэлийн нэр
- Судлаачдын нэрс, албан газрын харъяалал
- Илтгэлтэй холбоотой холбоо барих судлаачийн утас, e-mail хаяг
- Түлхүүр үг (3-5)
- Үндэслэл хэсэг (Судалгааны үндэслэл, дэвшүүлж буй таамаглал, үр дүнг багтаасан байна)
- Арга, аргачлал
- Үр дүн
- Хэлцэмж
- Дүгнэлт (дүгнэлтийг хэлцэмжтэй хамтатган хэлэлцүүлэг байдлаар бичиж болно)
- Талархал
- Ном зүй
- Англи хураангуй (**Title, Author list with affiliation, Abstract: Keywords, Background, Methods, Results, Conclusions**) 200 хүртэлх үгэнд багтаасан байна.

Хэрэв таны бүтээл шаардлагад нийцсэн бол хурлын бүтээлийн эмхтгэлийн номонд хэвлэгдэн хуралд оролцогсдод тараагдах бөгөөд илтгэх цагийг баталгаажуулсан урилга электрон шуудангаар болон утсаар илгээгдэх болно.

Илтгэл тавих хэлбэр: Амаар эсвэл ханын илтгэл

Жич: Файл дээрээ хуудсаа дугаарлахгүй байх

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ehemut.mn вэб хуудаснаас авна уу.

Холбоо барих утас: 99079105

Албан тушаал: Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Энхмаа

E-mail: enkhmaa.d@ncmch.gov.mn